

ХЭЛ - СОЁЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Ж.ДОЛГОРМАА

*МУИС-ийн Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Англи хэлний тэнхим
e-mail: dolgor_j @ yahoo.com*

Түлхүүр үг: хэл, хэл-соёлын шүтэлцээ, ертөнцийн зураглал

Өгүүллийн товч агуулга: Энэхүү өгүүлэлд бид хэл соёлын шүтэлцээ болон ертөнцийн зураглалын тухай ойлголтыг өгөх зорилт тавьсан болно.

Хэл нь утга санааг илэрхийлэгч тэмдгийн тогтолцоо юм. “Хэл бол нийт хүн төрөлхтний буюу эсвэл аль нэг үндэстний эрт дээр цагаас эдүгээ хүртэл бүтээн бий болгосон эдийн болон оюуны соёлын бүх зүйлийг тэмдэглэж нэрлэнгээ хуримтлуулан хадгалж, бас түүнийг үеэс үед уламжлуулан өвлүүлэх хэрэглүүр байдаг учраас үндэстний хэлийг үндэстний соёлын илэрхийлэл баримт хэмээн үзэж байгаа билээ” (Баянсан, 2002:100).

Хэл соёлын шүтэлцээний тухай санаа анх 18-р зууны үед үүссэн хэдий ч өнөөдөр хэл шинжлэлийн тулгамдсан асуудлын нэг байсаар байна. Иймээс бид энэхүү өгүүлэлдээ хэл-соёлын шүтэлцээний асуудлын талаар толилуулахаар шийдлээ. Хэл соёлын шүтэлцээ нь хэлний бүх түвшнээс үгийн сангийн түвшинд хамгийн түрүүнд илэрдэг. Аль ч улсын соёл, ахуй амьдрал, ёс заншил, хэл яриа нь өвөрмөц онцлогтой.

Хэл-сэтгэхүй, хэл-түүх, хэл-соёл салшгүй холбоотой юм. Хэл соёлын талаар эрдэмтэд олон янзаар тодорхойлсон байдаг. Гадаад дотоодын эрдэмтдийн олон тодорхойлолтоос дараах ишлэлүүдийг авъя.

Хэл бол тухайн үндэстний соёлын амьдралын суурь юм. Эрдэмтэн Ф.Соссюр “Ерөнхий хэл шинжлэл” (1916) номондоо “Хэл гэдэг дотроо бүх юм нь нарийн холбоо бүхий тогтолцоо юм” гэж баталжээ.

“Хэл нь тодорхой ард түмний үндэсний соёлыг хадгалах сан байдаг бөгөөд үүнтэй уялдан тухайн үндэстний хэлний нэгжүүд үндэсний соёл, онцлогийг агуулсан мэдээллийн эх булаг болдог. Хэл соёл хоёр ухамсрын хэлбэр болохын хувьд маш нягт уялдаатай үзэгдэл байдаг учраас үндэстний соёлын тухай асуудал, ялангуяа тухайн соёл-хэлний үндэстний сэтгэлгээг судална гэдэг бол хэлний тэмдгийнх нь соёлын учир холбогдлыг нээж гаргана гэсэн үг гэж ойлгож байна” (Баянсан, 2002: 98).

“Соёл нь тодорхой ард түмний түүхэн цаг хугацааны явцад хэвшин тогтсон амьдралын хэв маяг, сэтгэлгээний онцлогийг илэрхийлэх хэрэгсэл болдог байна” (Нансалмаа, 2005: 42)

“Соёл гэдэг нь хүмүүн төрөлхтний аж төрөлд гол цогц хийгээд бодитойгоор бие биедээ нөлөөлсний үйл бүтээл бөгөөд өргөн хийгээд явцуу утгатай хэмээн хуваадаг байна” (Базаррагчаа, 2001: 38).

“World Book volume IV”- д соёл гэдэг ойлголтыг нийгэм судлаачид амьдралын хэв маяг гэсэн утгаар хэрэглэдэг гэж тэмдэглэжээ. Францын соёл судлаач Жан Мари Бенуа “Соёл гэдэг нь хүнийг нэг төрөл зүйл болохынх нь хувьд тодорхойлж буй хүний үйл ажиллагааны өвөрмөц шинж юм. Соёлоос өмнөх үеийн хүнийг эрж олно гэдэг дэмий хэрэг Тэрээр түүхийн тавцан дээр гарч ирсэн явдлыг соёлын үзэгдэл гэж үзэх хэрэгтэй. Соёлын үзэгдэл нь хүний мөн чанартай маш гүнзгий холбоотой байж ер нь хүн гэсэн зүйлийг бүрэн тодорхойлдог юм” гэжээ (Гуревич, 2004: 37). Хэл бичгийн ухаан, гүн ухаан нь анх үүссэн цагаасаа эхлэн хэл - бодит байдал, хэл-нийгэм, хэл-соёл, соёл иргэншлийн нягт холбоо харилцан уялдааг хүлээн зөвшөөрч хөгжиж иржээ. Орчин үед хэл шинжлэл, нийгэм судлал, гүн ухаан, угсаатны зүй, сэтгэл судлал зэрэг шинжлэх ухааны уялдаат судалгаа юм үзэгдлийн мөн чанарыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Орчин үеийн хэл шинжлэл бүхэлдээ хүн төвтэй судлал болоод байна. Хэлний аливаа үзэгдэл баримтанд “цэвэр” хэл шинжлэлийн үзэл онол, арга зүйг үндэслэгээ болгодог нь хэл шинжээчдийн хэдэн үеийнхний гол арга барил байсаар иржээ. Гэвч хэл ямар нэгэн заяамал зүйл биш, харин хүний өөрийнх нь практик үйл ажиллагаа, ухамсар, сэтгэхүй, танин мэдэхүйн үйл ажиллагааны үр дүн гэдэг нь тодорхой болсон тэр үеэс “Хүн төвт хэл шинжлэл” /Anthropological linguistics/ үүсч хөгжиж эхэлжээ. Хүн төвт үзэл онолыг анх М.Гумбольдт боловсруулжээ. Хүний оюун ухааны чадавхи, ёс суртахууны төлөвшил нь бодит байдлыг хувирган өөрчлөхөд шийдвэрлэх нөлөө үзүүлэх болсон шинжлэх ухаан, технологи, мэдээллийн өнөөгийн эрин үед хүний тухай асуудал чухал болжээ. Өнөөдөр манай гараг дээр бүс нутгийн хүрээнд соёлууд өөр хоорондоо харилцахаас гадна, өөр өөрийн онцлог шинж бүхий соёлын томоохон бүс нутгууд ч оюун санааны хувьд ойртон нэгдэж, асуудлыг хамтын чармайлтаар шийдвэрлэх болсон. Гадаад хэл сурах болон заахтай холбогдон хэл шинжлэл, соёл судлал гэх хоёр өөр бие даасан шинжлэх ухаан ойртож байна. Хэл нь ард түмний соёлыг тодорхойлдог бөгөөд соёлын гадна оршихгүй. Соёл нэгтэй үндэстэн ястнууд биеэ биеэ сайн ойлгодог. Харин өөр өөр соёлтой хүмүүс ойлголцоход зөвхөн хэлний төдийгүй бас хэлний бус учир шалтгаанаас үүдсэн саад бэрхшээлтэй тулгардаг болохыг судлаачид тэмдэглэж ирсэн ба энэхүү ойлголтын дор хэл-соёлын хүчин зүйл байгаа гэж судлаачид үздэг байна. Нэг үндэстний хүрээнд өсөж торнисон хүн өөр нэг үндэстний соёлтой танилцан, үндэстний соёлын хэм хэмжээ баялгийг өөрийн болгон эзэмших явдлыг өөрөөр соёлжих (аккультураци) өөр соёл эзэмших гэж нэрлэдэг (Томтогтох, 2000: 22).

Сүүлийн жилүүдэд хэл ба соёл хоорондын харилцан холбоо, хэлний нийгэм болон оюун санаа-соёлын агуулгатай харилцаа холбоотой байдал, мөн түүнчлэн орчин үеийн нийгэм дэх хүн ба соёл хоорондын харилцан холбоо зэрэг асуудал нь хэл шинжээчид болон соёл судлаачдын анхаарлын төвд байна. Ямарваа нэгэн хэлийг сурах судлах гэдэг нь үнэн хэрэгтээ, тухайн үндэстний эрт дээр үеэс хуримтлуулан арвижуулж, үе уламжлуулан хөгжүүлж ирсэн утга соёлынх нь сан хөмрөгөөс хэлээр нь дамжуулан ойлгож, таньж мэдэх гэсэн үг юм.

Соёлын ертөнц маш олон төрөл бөгөөд гайхамшигтай юм. Соёл судлал нь бие даасан шинжлэх ухааны хувьд ХХ зууны эхэн үед бүрэлдэн тогтжээ. Энэхүү нэр томъёог анх америкийн антропологч Лесли Уайт (1900 - 1975) шинжлэх ухаанд хэрэглэсэн байна. Соёл судлал гэдэг нь соёлын олон талт шинжийн тухай болон төсөөгүй байдлын тухай, соёл – түүхийн үйл явцын зүй тогтлын тухай шинжлэх ухаан юм. Хүн төрөлхтөн олон янзын соёл бүхий хүмүүс хэрхэн амьдардаг тухай асар их хэмжээний баримт материал цуглуулсан байна. Энэ бүхнээс бид соёл гэдэг

нь ямар олон янз болохыг харж болно. Гэхдээ өнөөгийн шинжлэх ухаан зөвхөн энэ үндэслэлийг баримтлахад хангалтгүй юм. Учир нь өнөө үед хүн гадны нэг улс оронд очиход л хүмүүсийн ахуй зан заншил хэрхэн ялгаатай болохыг олж харах болно. Соёлын орон зайн энэ олон янз байдлын зэрэгцээ тэдгээр нь зарим нэг талаар нийтлэг шинжийг агуулна. Сайтар ажиглавал соёлын эсрэг тэсрэг шинжүүдэд хүртэл зарим талаар нийтлэг зүй тогтлыг олж үзэж болдог. Хэрэв энэ зүй тогтол байгаагүй бол соёл нь олон талаар урьдчилан харахын аргагүй хөгжиж, хүн түүний хөгжлийн логик дарааллыг тэмдэглэх аргагүй болно. Ингэснээрээ ерөнхий зүй тогтолт үзэгдэл болох соёлын тухай төсөөллийг олж авах аргагүй болох билээ.

Хэл, соёлыг хүнгүйгээр төсөөлөхийн аргагүй ээ. Тэдгээрийг бүрдүүлэн бий болгоход хүн онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүнтэй холбоотойгоор хүний хүчин зүйл гэдэг ойлголт бүхий л хүмүүнлэгийн, тухайлбал хэл шинжлэл-орон судлалын салбарын орчин үеийн эрдэмтдийн анхаарлын төвд байнга байдаг. Гохуа (1995: 42) “Хэл нь бодит байдлыг өөрчлөөд зогсохгүй, түүний хэлбэрийг өөрийнхөөрөө тусгадаг. Амьдралын гадаад нөхцөл байдал, материаллаг бодит байдал нь хүмүүсийн ухамсар, зан төлөвийг тодорхойлдог бөгөөд үгийн сан болон хэл зүйн хэлбэрт тусгалаа олдог. Хэлгүйгээр ертөнцийн зураглал бий болдоггүй. Ертөнцийн зураглал нь нийгмийн ухамсарт хэлний тусламжтайгаар хэлбэржин, тэмдэглэгддэг. Хэл нь ертөнцийг танин мэдэх зэмсэг бөгөөд түүний тусламжтай энэхүү танин мэдэхүйн үр дүн хэлбэрждэг” (Чинь Тхи Ким Нгок, 1999: 94 өөс дам ишлэв) гэжээ.

XIX зууны нэрт физикчид Г.Герц, М.Планк болон А.Эйнштейн нар ертөнцийн зураглал гэсэн нэр томъёог анх удаа бүтээлүүддээ ашиглаж ирсэн. Ертөнцийн зураглал гэдэг ойлголтыг судлан А.Эйнштейн өргөн хүрээний тайлбарыг өгсөн байдаг: “Хүн ямар нэг адил төстэй арга замаар ертөнцийн мэдрэхүйгээс ангижрахын тулд, ийм арга замаар ийм дүр зураглалаар бүтээгдсэн энэ дэлхийг тодорхой түвшинд өөрчлөхийг эрмэлзэн ертөнцийн талаарх энгийн тодорхой дүр зураглалыг өөртөө бий болгохыг эрмэлзэж байдаг” (Постовалова, 1988: 13 – аас дам ишлэв).

60-д оны үед кибернетикийн салбарт ертөнцийн зураглалын тухай асуудал хүчтэй тавигдаж эхэлсэн ба энэ үед ертөнцийн зураглалыг тодорхойлох явдалд кибернетикийн бүтээлүүд гол байр суурь эзэлж байжээ. Тухайн үед судалгааны объектыг хоёр бүлэгт хуваан үзэж байжээ. Үүнд: анхдагч загварчлалын тогтолцоонд - хэл, хоёрдогч загварчлалын тогтолцоонд- домог, шашин, аман зохиол, уран зохиол болон дүрслэх урлагийн бүтээлүүдийг авч үзэж байжээ (Постовалова, 1988: 15). Энэ хандлагын үүднээс соёл гэдэг нь хамт олноос өвлөн уламжлагддаг дурсамж дурдатгал биш хэмээн тайлбарладаг бөгөөд түүний гол зорилт нь ертөнцийн загварыг бий болгоход илэрхийллээ олдог хүнийг хүрээлэн байгаа ертөнцийн загварыг бий болгоход оршиж байв.

Хэлний ертөнцийн зураглал нь үндэсний соёлын өв уламжлалтай салшгүй холбоотой байж түүний илрэл нь болдог. Хэлний ертөнцийн зураглал нь ертөнцийн тухай хүний төсөөлөл бөгөөд ард түмний материаллаг ба оюуны амьдралтай салшгүй холбоотой.

Хүн төрөлхтний нийтлэг ертөнцийн зураглал, ард түмний үндэстний зураглал гэсэн хоёр зүйл зураглал байдаг. Сүүлийн жилүүдэд ертөнцийн үндэсний зураглалыг хэл судлаачид, соёл судлаачид болон заах арга зүйчид хэл, соёл судлалын чухал аспект болгон судалж байна. Аливаа хэл бие биенээсээ зөвхөн авиа зүй, хэл зүй, үгийн сангаараа төдийгүй мөн ертөнцийг үзэх үндэсний соёлын

өвөрмөц байдлаараа, өөрөөр хэлбэл, тухайн ард түмний хэлэнд нь тод илэрсэн, уг ард түмнийг хүрээлэн буй орчны элементүүд, шинж чанар, юмс үзэгдэлүүдээрээ ялгагдана. Зуун зуунд үндэсний өнгө төрхтэй тодорхой хэв шинжүүд хүмүүсийн ухамсарт бүрэлдэн бий болж хадгалагдсаар иржээ. Үүнд ахуй, ойлгон мэдрэхүй, хүмүүсийн итгэл бишрэл, сэтгэхүйн онцлогууд ордог. Тэдгээрт ард түмний язгуур уг сурвалж байдаг.

Хэл, шашин, философи, урлаг дахь гол ялгааг газар зүй, эдийн засаг, түүхэнд тулгуурлан тайлбарлах нь хүнд биш асуудал юм. Үндэсний соёл нь гайхалтай бүхэллэг байдаг. Тэдгээр нь дэлхийн соёлын олон өнгийг бүрдүүлдэг билээ. Түүх бидэнд өргөжин хөгжиж буй орчлонтой төсөө бүхий дүр зургийг өгч байна.

Ард түмнүүд улам бүр өөрийн үндэсний хэв маягт уусаж, улам бүр өөрийгөө танин мэдэх, илэрхийлэх тал руу тэмүүлэх болов. Ард түмнүүдийн соёлын түвшингийн тухай асуудлыг тэдний түүхэн сэтгэлгээний гүн гүнзгий, олон талт шинжээр тодорхойлдог. Өөрийн түүхийг хүндэтгэдэг ард түмэн үргэлж түүхэндээ хандаж, түүнээс суралцан, сургамж авч байдаг.

Өнгөрсөн үед бидний туулж өнгөрүүлсэн түүх өнөө үед олон талаараа давтагдаж байдаг. Энэ нь хүмүүс түүхэн өөр нөхцөлд оршдог боловч, адил төсөөтэй үйл явцад оролцон, туулж өнгөрүүлдгийн гэрч юм. Тодорхой нийгэм эдийн засгийн хувьд биеэ даасан, түүндээ тохирсон орчин үеийн улс төрийн байгууламжтай улс орнууд байна. Гэхдээ үүний хажуугаар ийм нийгэм нь хүмүүсийнх нь сэтгэлгээ, аж төрөх ёс, амьдралын хэвшлийг олон талаар тодорхойлдог уламжлалаа хадгалсаар байх нь бий.

Үгийн хэл шинжлэл-орон судлалын тухай онол нь бидний анхаарлыг хоёр гол зүйлд хандуулдаг: үгийн утга зүйн үндэсний-соёлын бүрэлдэхүүн хэсэг ба үгийн сангийн орчны эрчимтэй хөгжил, хэл яриан дахь түүний үүрэг. Үгийн хэл шинжлэл-орон судлалын онолын энэ хоёр тал нь бие биенийгээ үгүйсгэдэггүй, харин харилцан бие биендээ үйлчилж байдаг. Энэ байдал нь энэ чиглэлийн судлаачдад шинэ харьцуулсан материалуудыг шинжлэн судлаж, түүнд дүгнэлт хийх боломж олгож байна.

Хэл шинжлэл-орон судлалын салбарт хэл ба соёлын харилцаа холбооны асуудлыг эрдэмтэд үндэсний соёлын бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг. Ийм харилцаа холбоо нь хоёр талтай юм. Хэл нь мөн соёлыг илэрхийлэх арга зам, шалтгаан болдог. Үндэстний хэл бүрт бид үндэсний соёлын дүр төрхийг харж болох юм.

Хүн төрөлхтний нийтийн соёл нь манай гарагийн олон үндэстэн ястны үндэсний соёлын шилдэг ололтын цогц бол үндэсний соёл тухайн орны анги, нийгмийн давхрага, үндэсний олонх, цөөнхийн соёлын нэгдэл болно (Равдан, 2001: 8).

Зүйр үг, цэцэн үг, өвөрмөц хэллэг нь үндэстний соёлын нэгэн илэрхийлэл мөн. Тогтвортой нийлэмж нь тухайн хэлээр ярилцагч ард түмэн, улс үндэстний ертөнцийг үзэх үзэл, амьдралыг таних арга ухааныг илэрхийлэх үндсэн хэрэглүүр болдог бөгөөд тухайн улс үндэстний сэтгэхүй, сэтгэлгээний онцлогтой хамгийн их холбогддог. Иймээс бид тогтвортой нийлэмж нь монголчуудын ахуй, амьдрал, соёлын шууд тусгал болох талаар дараагийн өгүүлэлдээ бичих болно.

НОМ ЗҮЙ

- Арутюнов С. А.*, 1989. Народы и культуры: развитие и взаимодействие. М., х. 21
- Базаррагчаа Ц.*, 2001. Харьцуулсан соёл судлалын тухай ойлголт. МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг, 170/1, х. 38
- Баянсан Ж.*, 2002. Соёл хэл үндэстний сэтгэлгээ, х. 98 -100
- Брагина А.А.*, 1986. Лексика языка и культура страны: Изучение лексики в лингвострановедческом аспекте. М., х. 153-158
- Гуревич П.С.*, 2004. Соёл судлал. 1-р дэвтэр, х. 63-71
- Дорждавга Т.*, 2005. Соёл судлалын бүтээлийн эмхтгэл.
- Костомаров В.Г., Верецагин Е.М.*, 1976. Лингвострановедение в преподавании русского языка как иностранного, М, х. 46-49
- Нансалмаа Н.*, 2005. Үгийн сан судлал, х. 42
- Поставалова В.И.*, 1988, Картина мир в жизнедеятельности человека. Роль человеческого фактора в языке. Язык и картина мира. М., х. 15
- Равдан Э.*, 2001. Хэл, соёлын шүтэлцээний тухай, МУИС--ийн Эрдэм шинжилгээний бичиг, 170/1, х. 8
- Сүхбаатар Ц.*, 1998. Монгол хэлний найруулга зүй. х. 17-18
- Томтогтох Г.*, 2000 Монгол хэлний үндэсний онцлог бүхий үгсийн сан – утга зүйн судалгаа, х. 22
- Философский энциклопедический словарь*, 1996, М.
- Чинь Тхи Ким Нгок*, 1999. Проблема языка и культуры при изучении иностранных языков, М., х 95-115
- World Book Encyclopedia*, 1995. Vol. IV, х 1186-1190

SUMMARY

J.Dolgormaa

CONCEPT ON LANGUAGE AND CULTURE.

Language and psyche, language and history, language and culture are inextricably linked with each other. Language is a base of the culture of any nationality. The language is a repository of the national culture. Scientists consider that relationship between language and culture is a part of national culture. Moreover language becomes ways and cause to express culture.